



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот


Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, 2019 оны А/01 дүгээр албан даалгавар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр албан даалгавар, Хотын ерөнхий менежерийн 2019 оны 02 дугаар албан даалгаврын зарим заалтын хэрэгжилтэд буюу нийтийн тээврийн үйлчилгээний чанар соёл, хүртээмж, өнгө үзэмж цэвэр цэмцгэр байдал, зорчигчдын аюул, осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрэн хангасан байдалд хяналт тавьж, үзлэг шалгалт явуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Шалгалтын удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Нийтийн тээврийн үйлчилгээнд удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд үзлэг шалгалтыг явуулж, явц, үр дүнг 7 хоног тутамд Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Мягмар/-т, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар /Х.Булгаа/-т тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04-р сарын 08-нд
194 дугаар тушаалын дүгнэлт хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч | Ц.Мягмар Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга |
| Гишүүд | З.Цэвээндорж Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газрын Тээврийн хяналтын хэлтсийн дарга Б.Мөнхзул Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн П.Чойжилжав Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн Ц.Хадбаатар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Тээврийн хяналтын улсын ахлах байцаагч Н.Цогтоо Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсийн мэргэжилтэн, Цагдаагийн хошууч Ц.Мөнх-Очир Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ-ын Мэдээлийн технологи, техник ашиглалтын хэлтсийн дарга Д.Отгонсүрэн Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газрын Тээврийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Наранжаргал “Сити баз консалтинг” ХХК-ийн Хяналтын хэлтсийн ахлах Р.Ган-Эрдэнэ “Улаанбаатар смарт Карт” ХХК-ийн үйл ажиллагааны газрын захирал Н.Дамдинсүрэн Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбооны захирал |
| Нарийн бичгийн дарга | Ц.Наранцэцэг Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн |

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04 сарын 09 өдрийн
А/194 дугаар тушаалын дугаар хавсралт

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР СОЁЛ,
ХҮРТЭЭМЖ, ӨНГӨ ҮЗЭМЖ ЦЭВЭР ЦЭМЦГЭР БАЙДАЛ,
ЗОРЧИГЧДЫН АЮУЛГҮЙ ЗОРЧИХ НӨХЦӨЛ БАЙДАЛД
ХЯНАЛТ ТАВЬЖ, ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО.

1.1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 тоот албан даалгавар, Хотын ерөнхий менежерийн 2019 оны 02 тоот албан даалгаврын зарим заалтын хэрэгжилтэд буюу нийтийн тээврийн үйлчилгээний чанар соёл, хүртээмж, өнгө үзэмж цэвэр цэмцгэр байдал, зорчигчдын аюул, осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байдал, нийтийн тээврийн хэрэгслэлийн мэдээлэл, цахим картын тоноглол бусад төхөөрөмж бүрэн бүтэн болон ашиглалтын байдалд үзлэг шалгалт явуулж, үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА.

2.1. **Хамрах хүрээ:** Шалгалтад нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн болон хот орчмын чиглэлд их болон дунд багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэгч 19 аж ахуй, нэгж. байгууллага “Улаанбаатар Смар карт” ХХК-ийн үйл ажиллагаа, “Жей Си Дэко” ХХК-ийн автобусны зогсоолуудын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.

2.2. **Хугацаа:** Шалгалтын ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс 2019 оныг дуустал батлагдсан графикайн дагуу зохион байгуулна.

2.3. Шалгалтын ажлын графикт хугацаа, ажлын хэсгийн хуваарийг удирдамжийн 1 дүгээр хавсралтаар, жолооч болон тээврийн хэрэгслийг шалгах хүснэгтийг 2 дугаар хавсралтаар баталсан байна.

ГУРАВ. ШАЛГАХ ЧИГЛЭЛ.

3. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар соёлыг сайжруулах чиглэлээр Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад:

3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд өнгө үзэмжтэй цэвэр цэмцгэр, аюулгүй орчинд үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх, зорчигчдыг аюул, осолгүй, тав тухтай зорчих нөхцлийг бүрэн хангах,

3.2. Нийтийн тээврийн үйлчилгээний цагийн хуваарийг чанд баримтлан, мөрдөж ажиллах,

3.3. Нийтийн тээврийн хэрэгслийн дотор, гадна талыг тогтмол угааж, зорчигчдын суудал бүрээстэй, түшлэг, бариулыг ариутган арчиж, үйлчилгээнд гаргах,

3.4. Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг өдөр бүр шалгаж, механикийн ажлын хариуцлагыг сайжруулж, тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргах, аюулгүй байдлыг хангуулах хүрээнд ээлжийн жолоочийг ажиллуулсан, стандарт шаардлагыг баримталсан байдал,

3.5. Нийтийн тээврийн хэрэгсэлд суурилагдсан зогсоолын нэрийг мэдээлэх (зарлах төхөөрөмж, дэлгэцэн хаяг) төхөөрөмж болон камерын хэвийн ажиллагаа, түүний ашиглалтын бүрэн бүтэн байдал,

3.6. Шугам замд гарч буй жолооч нарт дараах асуудлуудыг анхааруулан үүрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

А. Хөдөлгөөнд оролцох явцдаа тамхи татах, дуу хөгжим чанга тавих, утсаар ярих, дүрс бичлэг үзэх зэрэг өөрийнхөө анхаарлыг сарниулсан үйлдэл хийхгүй байх,

В. Нийтийн тээврээр үйлчлүүлж буй зорчигчдыг цахим картаар үйлчлүүлэх шаардлага тавьж, бэлэн мөнгө авахгүй байх, тэдгээрт байгууллага бүр дотоод хяналтыг хэрэгжүүлэх,

С. Хүндэтгэх шалтгаангүйгээр нийтийн тээврийн хэрэгслийг байр эзлэх, эсхүл саадыг тойрон гарах, огцом тоормослох, хөдлөх, хурд хэтрүүлэх, хэт удаан явах зэргээр зорчигчийн тав тухыг алдагдуулахгүй байх,

Д. Автобусны зогсоол руу бүрэн орж зогсож, үйлчлүүлэгчийг аюулгүй зорчих нөхцөлийг хангах,

3.7. Нийтийн тээврийн автобусны зогсоолуудын тохижилт, цэвэр үзэмжтэй болон бүрэн бүтэн байдал, нийтийн тээврийн үйлчилгээний маршрут, чиглэлийг бүрэн байрлуулсан байдал,

3.8. Замын хөдөлгөөн зохион байгуулалтад буюу авто замын 1-р эгнээг чөлөөлөх, нийтийн тээврийн хэрэгслийг чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байдлыг тус тус хамааруулж үзнэ.

ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.

4.1. Шалгалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулна.

4.2. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг бүхий л хэлбэрээр баримтжуулж болох ба шалгалт хийх цэгүүдэд удирдамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан шалгах хүснэгтийн дагуу зохион байгуулна.

4.3. Шалгалтын явцад Нийтийн тээврийн үйлчилгээний газраас шалгалт хийх ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажлын чиглэл заавар зөвлөмж өгнө.

4.4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь хяналт шалгалтын ажлыг удирдан зохион байгуулна.

4.5. Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ нь шаардлагатай хугацаанд шугам замд хөдөлгөөнд оролцож буй нийтийн тээврийн хэрэгсэл зам тээврийн осол, замын хөдөлгөөний зөрчил гаргасан тухай мэдээллээр хангаж ажиллана.

4.6. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар нь хяналт шалгалтын явцад удаа дараа зөрчил гаргаж буй аж ахуйн нэгж, иргэнд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллана.

4.7. Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, гадна дотор цэвэрлэгээ нь стандартын шаардлага хангасан эсэхэд–Авто тээврийн хяналтын улсын байцаагч нар баазаас гарахад нь хяналт тавина.

4.8. "Сити баз консалтинг" ХХК-ийн шалгагч нар батлагдсан хуваарийн дагуу нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод цахим төлбөрийн картын зөв ашиглалтыг

хянах, тээврийн хэрэгслийн угаалга цэвэрлэгээ, чиглэлийн мэдээллийн болон бусад төхөөрөмж хэвийн ажиллаж байгааг ажлын хэсгийн бүрэлдхүүнтэй хамтран шалгана.

4.9. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгалтын үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг нэгтгэн Улаанбаатар хотын Ерөнхий менежерт долоо хоног бүрийн Лхагва гаригийн 16 цагт танилцуулна.

4.10. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг тооцож, нэгтгэж танилцуулна.

4.11. Илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад Автотээврийн хяналтын улсын байцаагч нар арга хэмжээ тооцож, хугацаатай албан шаардлага хүргүүлнэ.